

**“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 06

№ 23/08

Дархан –Уул аймаг

**“ Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай**

“ Дархан зочид буудал” ХК-ийн 2023 оны 03 сарын 06-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс санал авсан хуудасны дүн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэхь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. **“Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 28 -ны 14:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг 2-р хороо Центропонт төв “ Бурхан халдун групп” –ын байрнд хуралдуулсугай.**
2. **“Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.**
 - **Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.**
 - **Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах**
 - **2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах.**
3. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТХТөвөөс 2023 оны 03 сарын 29 –ны өдөр / **бүртгэлийн өдөр** /-өөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд 2023 оны 03 сарын 10-ны өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр , 2022 оны 03 сарын 24-ны өдөр дахин мэдээлхийг хурал зохион байгуулах комиссын дарга С.Дагиймаа-д даалгасугай.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг ТУЗ-ийн нарийн бичиг С.Дагиймаа-д гаргаж өгхийг санхүүд даалгасугай.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь **Хавсралт1-д** заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “ саналын хуудас”ны агуулгыг **Хавсралт 2-д** зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг **2023 оны 04 сарын 28-ны өдрийн 14 цагаар** тасалбар болгосугай.
9. Компанийн ээлжит хурал удирдах даргаар ТУЗ-ийн дарга П.Алимаа-г зохион байгуулах комиссын даргаар С.Дагиймаа-г, Тооллогын комиссын даргаар Ж.Энхжаргал, гишүүнээр С.Оюундэлгэрийг тус тус томилсугай.
10. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг **Хавсралт3** –д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо,Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга С.Дагиймаа-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

[Signature] П.Алимаа

ГИШҮҮД:

[Signature] Н.Мөнхдаш

[Signature] Б.Мягмардаш

[Signature] Д.Даянбилгүүн

[Signature] Н.Пүрэвдаш

[Signature] Э.Мянганбаяр

[Signature] Б.Баярбат

[Signature] Л.Ариунтуяа

[Signature] Л.Ариунзаяа

